

**ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
САЙДЫН ТУШААЛ**

2023 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Дугаар

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1."Хохирогчийг ажлын байраар хангах, мэргэжлийн сургалтад хамруулах үйлчилгээ үзүүлэх журам"-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2.Тушаалын хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр, эрхлэлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /С.Дамбий/, Гэр бүлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Н.Баярмаа/-т тус тус даалгасугай.

3.Энэ тушаал гарсантай холбогдуулан Хөдөлмөрийн сайдын 2015 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн А/135 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

Х.БУЛГАНТУЯА

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын
..... оны дугаар сарынны өдрийн
..... дугаар тушаалын хавсралт

ХОХИРОГЧИЙГ АЖЛЫН БАЙРААР ХАНГАХ, МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТАД ХАМРУУЛАХ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг ажлын байраар хангах, мэргэжлийн сургалтад хамруулах үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2.Хохирогчийг ажлын байраар хангах, мэргэжлийн сургалтад хамруулах үйлчилгээ үзүүлэхэд Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хууль, Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хууль, Төрийн болон албаны нууцын тухай хууль бусад холбогдох хууль тогтоомжийг баримтална.

1.3.Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2-т заасан хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч /цаашид “хохирогч” гэх/ нь энэхүү журамд заасан үйлчилгээнд хамрагдана.

1.4.Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасны дагуу хамгаалалтад байгаа хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг мэргэжлийн сургалтад хамруулах, эсхүл ажлын байраар хангах ажлыг энэхүү журамд заасны дагуу Хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага аймаг, нийслэл, дүүргийн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институттэй хамтран зохион байгуулна.

1.5.Эрх бүхий байгууллагаас хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн амь нас, эрүүл мэндэд бодитой аюул, заналхийлэл бий болсныг тогтоож Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-т заасны дагуу оршин суугаа газраас нь нүүлгэн шилжүүлсэн тохиолдолд хохирогчийн хамт амьдардаг гэр бүлийн гишүүдийг мэргэжлийн сургалтад хамруулах, эсхүл ажлын байраар хангахад энэ журам мөн адил хамаарна.

1.6.Энэхүү журмын үйлчлэл нь хохирогч ажлын байранд зуучлуулсан, эсхүл тогтмол ажил эрхэлж эхэлснээр дуусгавар болно.

Хоёр.Журмыг хэрэгжүүлэхэд баримтлах зарчим

2.1.Энэ журамд заасан үйлчилгээ үзүүлэхэд дараах зарчмыг баримтална:

2.1.1.хохирогчийн нэр төрийг хүндэтгэх;

- 2.1.2.ялгаварлан гадуурхахгүй байх;
- 2.1.3.хүний хувийн мэдээллийг хамгаалах;
- 2.1.4.сургалтыг чадамжид суурилсан хэлбэрээр зохион байгуулах;
- 2.1.5.сайн дурын үндсэн дээр мэргэжлийн сургалт, хөдөлмөр эрхлэлтэд хамрагдах;
- 2.1.6.хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, шаардлагад нийцсэн байх;
- 2.1.7.хөдөлмөрлөх тэгш эрх, адил боломжийг хангах.

Гурав.Хохирогчид үзүүлэх үйлчилгээ үзүүлэх

3.1.Хохирогчид энэхүү журмын дагуу дараах үйлчилгээг үзүүлнэ:

- 3.1.1.хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээнд хамруулах;
- 3.1.2.хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд хамруулах;
- 3.1.3.мэргэжлийн анхан шатны ур чадвар эзэмшүүлэх сургалтад хамруулах
- 3.1.4.мэргэжлийн болон мэргэшүүлэх сургалтад хамруулах;
- 3.1.5.ажлын байраар хангах;

3.2.Хохирогчийн хүсэлтийг үндэслэн мэргэжлийн болон техникийн боловсрол олгох сургалтад хамруулж болно.

3.3.Энэхүү журмын 3.1-д заасан үйлчилгээнд хамрагдах хүсэлтээ хохирогч өөрөө, эсхүл энэхүү журмын 3.4-т заасан байгууллагаар уламжлан Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад гаргана.

3.4.Хохирогч энэхүү журмын 3.3-т заасны дагуу хүсэлтээ бусад байгууллагаар дамжуулан гаргах тохиолдолд дараах байгууллагад хүсэлтээ гаргана:

3.4.1.хохирогчид үйлчилгээ үзүүлж байгаа төрийн бус байгууллага;

3.4.2.цагдаа болон тагнуулын байгууллагын хяналтад байгаа бол тухайн байгууллага.

3.5.Энэхүү журамд заасан үйлчилгээ үзүүлэх байгууллага нь хүсэлт гаргасан хохирогчид хөдөлмөр эрхлэх ур чадварын үнэлгээ хийж, тухайн иргэний ур чадвар, онцлог хэрэгцээг тодорхойлсны үндсэн дээр хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа/хөтөлбөр/, холбогдох сургалтад хамруулах, ажилд жуучлах үйлчилгээг зохион байгуулна.

3.6.Хүсэлт гаргасан хохирогчийг энэхүү журмын 3.1, 3.2-т заасан үйлчилгээнд хамруулах ажлыг Хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нэн даруй эхлүүлж, холбогдох харьяа байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.

3.7.Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хүсэлт гаргасан хохирогчийг Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-д заасан мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын байгууллагад 14-өөс доошгүй хоногийн сургалтад хамруулна.

3.8. Аймаг, нийслэлийн, дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллага зохих мэргэжилтэй, мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшсэн, хөдөлмөр эрхлэлтийн болон мэргэжлийн сургалтад хамрагдсан хохирогчийг нэн даруй ажлын байранд жуучилна.

3.9. Хохирогчийг ажлын байраар хангаж чадаагүй тохиолдолд түүнийг харьяа аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага ажил хайгчаар бүртгэнэ.

3.10. Хохирогч нь 13-18 хүртэл настай байх тохиолдолд тухайн хүүхдийн эрүүл мэнд, өсөлт хөгжилтөд сөргөөр нөлөөлөхгүй, сурч боловсроход саад учруулахгүй нөхцөлд эцэг эх, асран хамгаалагчийн зөвшөөрөлтэйгөөр Хөдөлмөрийн тухай хуулийн 142 дугаар зүйлд заасныг баримтлан энэхүү журамд заасан үйлчилгээг үзүүлж болно.

3.11. Энэхүү журмын 3.1-д заасан үйлчилгээ үнэ төлбөргүй байна.

3.12. Энэхүү журмын 3.1-д заасан үйлчилгээ үзүүлэх явцад хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон талаарх бүхий л мэдээллийг нууцална.

Дөрөв. Төрийн бус байгууллага, олон улсын байгууллагын үйл ажиллагаа

4.1. Энэхүү журмын 3 дугаар зүйлд заасан үйлчилгээ үзүүлэхэд төрийн бус байгууллага болон олон улсын байгууллага тусламж дэмжлэг үзүүлэх, шаардлагатай үйл ажиллагааг хэсэгчлэн эсхүл бүхэлд нь хэрэгжүүлэх байдлаар хамтран ажиллаж болно.

4.2. Энэхүү журамд заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх зорилгоор хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага сургалт эрхлэх зөвшөөрөл бүхий байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж болно.

4.3. Ажил үүргийн дагуу туслалцаа, үйлчилгээ үзүүлж байсан хүн, хуулийн этгээд хохирогчийн мэдээллийг задруулахыг хориглоно.

Тав. Санхүүжилт

5.1. Журмын хэрэгжилтийг зохион байгуулах хөрөнгийг дараах эх үүсвэрээс бүрдүүлнэ:

5.1.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас хуваарилсан хөрөнгө;

5.1.2. Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтыг дэмжих сангаас хуваарилсан хөрөнгө;

5.1.3. Ажилгүйдлийн даатгалын сангаас хуваарилсан хөрөнгө;

5.1.4. Улсын болон орон нутгийн төсвөөс хуваарилсан хөрөнгө;

5.1.5. Хандив, тусламж.

Зургаа.Үйл ажиллагааны болон санхүүгийн тайлагналт, хяналт үнэлгээ шинжилгээ

6.1.Энэхүү журмын дагуу үйлчилгээ авахаар хүсэлт гаргасан хохирогчийг энэхүү журмын 3.1-д заасан үйлчилгээнд хамруулсан байна.

6.2.Аймаг, нийслэл, дүүргийн Хөдөлмөрийн эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллага, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институт нь Хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад журмын хэрэгжилтийн сарын тайлан мэдээг дараа сарын 03-ны дотор, улирлын мэдээ, тайланг дараа улирлын эхний сарын 03-ны дотор, Хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн дэргэдэх Хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах, мэргэжлийн удирдлагаар хангах, хяналт тавих чиг үүрэг бүхий Дэд зөвлөл сарын тайлан мэдээг дараа сарын 03-ны дотор, улирлын тайлан мэдээг дараа улирлын эхний сарын 03-ны дотор тус тус хүргүүлнэ.

6.3.Дэд зөвлөл тайланг хүлээн авч, үйлчилгээ үзүүлсэн хохирогчийн тухай мэдээллийг ажлын 5 хоногийн дотор хүн худалдаалах гэмт хэргийн мэдээллийн санд оруулна.

6.4.Хохирогчид энэхүү журамд заасан үйлчилгээ үзүүлэх явцад хохирогч хүн худалдаалах болон бусад эрүүгийн хэргийн хохирогч болох эрсдэлтэй байх нөхцөл байдал илэрсэн тохиолдолд үйлчилгээ үзүүлж байгаа байгууллага энэ талаар цагдаагийн байгууллагад шуурхай мэдээлнэ

6.5.Журмын хэрэгжилтийн явц, үр дүнгийн үнэлгээг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институт хагас, бүтэн жилээр хийж, тухай бүр холбогдох байгууллагад тайлагнана.

6.6.Журмын хэрэгжилтэд Дэд зөвлөл хяналт тавих, тайлан мэдээг сонсох бөгөөд шаардлагатай тохиолдолд хяналт шалгалт хийнэ.

Долоо.Бусад

7.1.Энэхүү журмыг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

7.2.Энэ журмыг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.